



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга


1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



Аудитын санал дүгнэлт:



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.28 № 48

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

ОРХОН АЙМГИЙН 19 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
В.БАДАМГАРАВ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \aiban bichig\ 2022-A4.doc



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,992,149.00</u>	<u>37,308,439.00</u>
33	АВЛАГА	1,340,011.00	1,340,011.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,340,011.00	1,340,011.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,652,138.00	35,968,428.00
351	Түүхий эд материал	14,912,600.00	13,185,700.00
35110	Тусгай зориулалттай материал	14,072,200.00	12,542,300.00
35130	Эм боох материал	840,400.00	643,400.00
354	Хангамжийн материал	23,739,538.00	22,782,728.00
35410	Бичиг хэргийн материал	1,111,550.00	665,940.00
35420	Аж ахуйн материал	22,489,988.00	22,116,788.00
35460	Хүнсний материал	138,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,149,181,059.42</u>	<u>1,117,682,411.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,149,181,059.42	1,117,682,411.90
392	Биет хөрөнгө	926,461,059.42	894,962,411.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	974,770,279.04	974,770,279.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,473,625.36)	(99,710,438.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,468,607.00	46,754,107.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,733,448.69)	(31,957,747.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,358,167.50	23,358,167.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,928,920.07)	(18,251,955.67)
393	Биет бус хөрөнгө	222,720,000.00	222,720,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(100,000.00)	(100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	222,720,000.00	222,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,189,173,208.42</u>	<u>1,154,990,850.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,189,173,208.42	1,154,990,850.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,189,173,208.42	1,154,990,850.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	432,811,014	432,811,014
51101	Өмч: - төрийн	210,091,014.00	210,091,014.00
512	Хуримтлагдсан үр дүн	(316,100,932.66)	(350,283,290.18)
51210	Өмнөх үеийн үр дүн	(316,100,932.66)	(316,100,932.66)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(34,182,357.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,072,463,127.08	1,072,463,127.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,189,173,208.42</u>	<u>1,154,990,850.90</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	422,295,670.00	416,659,600.00
122	Тусламжийн орлого	5,248,500.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	5,248,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	414,570,670.00	411,090,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	379,067,000.00	375,426,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	379,067,000.00	375,426,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	530,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,133,600.00	35,133,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,133,600.00	35,133,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	370,070.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	370,070.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,598,167.54	450,841,957.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,598,167.54	450,841,957.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,835,131.54	436,695,768.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,200,498.00	312,770,670.00
210101	Үндсэн цалин	201,511,216.00	232,585,299.00
210102	Нэмэгдэл	84,182,582.00	57,266,032.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,387,200.00	1,022,800.00
210104	Урамшуулал	23,119,500.00	21,896,539.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,381,919.00	41,169,252.00
210201	Тэтгэврийн даатгал	26,950,319.00	28,709,713.73
210202	Тэтгэмжийн даатгал	3,107,900.00	3,114,910.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,486,300.00	2,491,928.12
210204	Ажилгүйдлийн даатгал	621,600.00	622,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,215,800.00	6,229,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,090,247.00	21,593,158.00
210301	Гэрэл, цахилгаан	3,703,554.00	3,910,027.00
210302	Түлш, халаалт	10,446,591.00	14,613,197.00
210303	Цэвэр, бохир ус	5,940,102.00	3,069,934.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,425,390.00	4,575,450.00
210401	Бичиг хэрэг	389,600.00	918,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,300.00	119,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,129,430.00	358,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,815,800.00	1,117,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,500.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,760.00	2,061,900.00
2105	Нормативт зардал	20,927,905.00	17,569,911.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,519,460.00	1,178,000.00
210502	Хоол, хүнс	19,408,445.00	16,391,911.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,136,500.00
210604	Урсгал засвар	-	1,136,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813,900.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,800.00	-



19-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	688,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,995,272.54	37,880,827.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	194,000.00	1,096,680.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,661,272.54	36,784,147.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,763,036.00	14,146,189.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,043,353.00	12,403,942.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,043,353.00	12,403,942.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,519,683.00	1,742,247.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,519,683.00	1,742,247.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(30,302,497.54)	(34,182,357.52)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	739,750.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	739,750.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(739,750.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(31,042,247.54)	(34,182,357.52)



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(316,100,932.66)	1,189,173,208.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(316,100,932.66)	1,189,173,208.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(316,100,932.66)	1,189,173,208.42
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(316,100,932.66)	1,189,173,208.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(316,100,932.66)	1,189,173,208.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,182,357.52)	(34,182,357.52)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,811,014.00	1,072,463,127.08	(350,283,290.18)	1,154,990,850.90



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	417,865,227.00	419,977,404.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,865,227.00	419,977,404.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	379,067,000.00	375,426,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	379,067,000.00	375,426,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	530,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,133,600.00	35,133,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,133,600.00	35,133,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,664,627.00	8,886,904.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,664,627.00	8,886,904.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	417,865,227.00	419,977,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,865,227.00	419,977,404.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,437,564.00	396,944,311.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,200,498.00	312,770,670.00
210101	Үндсэн цалин	201,511,216.00	202,916,186.00
210102	Нэмэгдэл	84,182,582.00	87,170,630.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,387,200.00	864,755.00
210104	Урамшуулал	23,119,500.00	21,819,099.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,381,919.00	41,169,252.00
210201	Тэтгэврийн даатгал	26,950,319.00	28,709,752.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,107,900.00	3,114,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,486,300.00	2,491,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	621,600.00	622,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,215,800.00	6,229,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,090,247.00	21,593,158.00
210301	Гэрэл, цахилгаан	3,703,554.00	3,910,027.00
210302	Түлш, халаалт	10,446,591.00	14,613,197.00
210303	Цэвэр, бохир ус	5,940,102.00	3,069,934.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,683,130.00	2,195,300.00
210401	Бичиг хэрэг	27,500.00	315,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,300.00	119,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,308,230.00	1,331,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,100.00	428,050.00
2105	Нормативт зардал	20,092,170.00	16,698,911.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,000.00	40,000.00
210502	Хоол, хүнс	19,817,870.00	16,253,911.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	179,300.00	405,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,136,500.00
210604	Урсгал засвар	-	1,136,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813,900.00	-



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,800.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	688,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,175,700.00	1,380,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,035,700.00	1,380,520.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,427,663.00	23,033,093.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,864,627.00	8,886,904.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,664,627.00	8,886,904.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,043,353.00	12,403,942.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,043,353.00	12,403,942.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,519,683.00	1,742,247.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,519,683.00	1,742,247.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 19 дүгээр цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Орхон аймгийн 19 дүгээр цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 421,925.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,328.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,746.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд дахин үнэлэхэд тайлант оны нийт орлого 416,659.6 мянган төгрөг болж төлөвлөлтийн үеийн материаллаг байдлаас 78.9 мянган төгрөгийн зөрүү үүссэн тул материаллаг байдлыг дахин шинээр тогтоож 2021 оны нийт орлого 416,659.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож 6,249.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75%-иар 4,687.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 19 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,182.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	38,652.1	35,968.4	-2,683.7
Үндсэн хөрөнгө	1,149,181.1	1,117,682.4	-31,498.7
Нийт хөрөнгө	1,189,173.2	1,154,990.9	-34,182.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,189,173.2	1,154,990.9	-34,182.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,189,173.2	1,154,990.9	-34,182.4

Бараа материалын данс 35,968.4 мянган төгрөг болж 2,683.7 мянган төгрөгөөр буурсан нь 2,061.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,117,682.4 мянган төгрөг болж 31,498.7 мянган төгрөгөөр буурсан нь тоног төхөөрөмж 5,285.5 мянган төгрөгийн орлого бүртгэж, тайлант оны элэгдлийн зардалд 36,784.1 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,154,990.9 мянган төгрөг болж 34,182.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.



19-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 5,636.0 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 1,756.2 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 19-р цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 569,551.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 569,551.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 194,124.5 мянган төгрөгөөр бууруулан 375,426.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 375,426.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 35,133.6 мянга нийт 410,560.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 396,414.3 мянган төгрөгийг зарцуулж, 14,146.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 396,414.3 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 973.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,398.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 536.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 250.0 мянган төгрөгийн ариутгалын зардал, 280.0 мянган төгрөгийн тендерийн баримт бичгийн үнэ нийт 530.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал



Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн 19-р цэцэрлэг нь 2021 онд нийт 500,113.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 500,113.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн 12-р зүйл, 14-р зүйлийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,926.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,926.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа: Аудитаар хийгдсэн залруулга байхгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4 “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эрхлэгчийн тушаалаар тооллогын комисс томилогдож, тооллого хийсэн боловч хөрөнгийн тооллого үр дүнгүй, анхан шатны баримтыг бүрэн хангуулж ажиллаагүй. Мөн бараа материалын орлого, зарлага, дэлгэрэнгүй тайлангууд баримтын үнэн зөв түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, хянаж, шалгасан ажилтны гарын үсэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж үйлдсэн болон хянасан ажилтны гарын үсгээр баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	19-р цэцэрлэг	2	1,926.5							2	1,926.5